



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 11 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 435

Улаанбаатар
хот

“Тавантолгой төмөр зам” ХХК-ийн талаар
авах зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3, Төмөр замын тээврийн тухай хуулийн 9.1.1, Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын 2 дахь заалтын 2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Монголын төмөр зам” ТӨХК хэрэгжүүлэхээр тогтоосугай.

2. Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах асуудлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтод тус тус даалгасугай.

3. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн хэрэгжилт, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зохих дүгнэлт гаргуулах арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ш.Мөнхцэрэн)-д тус тус даалгасугай.

4. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусгахад шаардагдах эх үүсвэрийг тооцож саналаа танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх удирдлага (Ж.Ганбат)-д тус тус даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ, дүрэмд өөрчлөлт оруулах, бүтэц, зохион байгуулалтыг зохих журмын дагуу шинэчлэх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай.

6. Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтоор шинээр баригдах хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг тооцож, хэрхэн санхүүжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд

С.Бямбацогт, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Одхүү)-д тус тус даалгасугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Зам, тээврийн хөгжлийн сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

С.БЯМБАЦОГТ

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ ХХК 6375405 ☒ СБА3433	
Бүртгэсэн № <u>737</u>	Карт №
Огноо <u>2022.12.16</u>
<u>10</u> цаг <u>59</u> минутад
.....д	
ШИЛЖҮҮЛЭВ.	